



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/100/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор С.Оргил  
Утас: 99197346

Цахим хаяг: [Info@shinjenmagadlakhui-audit.mn](mailto:Info@shinjenmagadlakhui-audit.mn)

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 77

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
И.АТАРСАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2,076,574.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 2,053,949.6 мянган төгрөгийг зарцуулж 22,624.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,251,112.20	22,624,557.72
312	Банканд байгаа бэлэн мөнгө	63,251,112.20	22,624,557.72
3121	Төгрөг	63,251,112.20	22,624,557.72
31211	Төрийн сангийн харилцах	63,251,112.20	22,624,557.72
33	АВЛАГА	1,303,260.49	99,006.67
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,303,260.49	99,006.67
35	БАРАА МАТЕРИАЛ	163,850,686.28	176,883,079.78
351	Түүхий эд материал	81,835,568.00	87,901,200.00
3511	Тусгай зориулалттай материал	81,587,468.00	87,674,100.00
3513	Эм боох материал	248,100.00	227,100.00
354	Хангамжийн материал	68,125,118.28	72,781,879.78
3541	Бичиг хэргийн материал	13,684,959.28	25,350,321.78
3542	Аж ахуйн материал	50,161,318.00	39,950,618.00
3544	Түлш, шатах тослох материал	461,200.00	0
3545	Барилгын засварын материал	1,882,800.00	5,792,800.00
3546	Хүнсний материал	1,934,841.00	1,688,140.00
356	Мал амьтад	13,890,000.00	16,200,000.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	228,405,058.97	199,606,644.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,388,855,702.81	3,686,146,775.23
392	Биет хөрөнгө	3,354,051,702.81	3,651,342,775.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,582,480,231.00	3,822,722,331.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-398,578,411.00	-464,947,830.91
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	234,093,217.26	300,825,138.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,717,148.73	-118,413,394.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,906,286.81	86,435,436.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,242,990.29	-36,635,342.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,436,350.00	60,901,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,282,439.70	-22,109,770.40
39217	Ном	20,956,607.46	22,564,607.46
393	Биет бус хөрөнгө	34,804,000.00	34,804,000.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,500,000.00	-1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,804,000.00	34,804,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,388,855,702.81	3,686,146,775.23
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,617,260,761.78	3,885,753,419.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	444,935.98	16,233,390.00
413	Өглөг	444,935.98	16,233,390.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		3,461,530.00
4136	Бусад өглөг		12,771,860.00
41361	Байгууллагад төлөх өглөг		12,771,860.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	444,935.98	16,233,390.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,616,815,825.80	3,869,520,029.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	393,058,319.88	393,058,319.88

512	Хуримтлагдсан үр дүн	3,039,750,539.69	3,292,454,743.29
5121	Өмнөх үеийн үр дүн	3,039,750,539.69	3,039,750,539.69
5122	Тайлант үеийн үр дүн		252,704,203.60
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,006,966.23	184,006,966.23
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,616,815,825.80	3,869,520,029.40
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,617,260,761.78	3,885,753,419.40

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,855,266,800.00	2,014,695,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,756,019,400.00	1,923,404,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,756,019,400.00	1,923,404,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,247,400.00	91,291,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,247,400.00	91,291,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,850,171.30	404,146,313.50
120	Нийтлэг татварын бус орлого	38,850,171.30	404,146,313.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	465,000.00	300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	465,000.00	300,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	21,274,390.70	376,807,231.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	17,110,780.60	27,039,082.50
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,894,116,971.30	2,418,842,013.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,944,720,063.64	2,166,137,809.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,860,483,350.64	2,088,501,328.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,342,178,213.36	1,571,482,237.02
210101	Үндсэн цалин	849,400,875.22	974,456,589.32
210102	Нэмэгдэл	404,772,818.14	472,453,697.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт		36,520,000.00
210104	Урамшуулал	88,004,520.00	88,051,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,468,843.47	197,925,743.53
210201	Тэтгэврийн даатгал	114,759,865.90	133,612,580.14
210202	Тэтгэмжийн даатгал	13,501,160.72	15,719,127.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,603,062.73	10,519,867.69
210204	Ажилгүйдлийн даатгал	6,520,950.87	7,614,833.77
210205	Эрүүл мэндийн даатгал	26,083,803.25	30,459,334.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,843,886.00	87,169,230.00
210301	Гэрэл, цахилгаан	16,346,996.00	22,192,701.00
210302	Түлш, халаалт	59,297,400.00	59,114,029.00
210303	Цэвэр, бохир ус	5,199,490.00	5,862,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,307,400.00	18,470,288.00
210408	Бараа материал акталсны зардал	6,307,400.00	18,470,288.00
2105	Нормативт зардал	36,703,020.00	47,009,350.00
210502	Хоол, хүнс	36,703,020.00	47,009,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,645,000.00	183,350.00

210604	Урсгал засвар	12,645,000.00	183,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,721,942.35	11,860,741.77
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,721,942.35	11,860,741.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,615,045.46	154,400,388.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,365,432.07	34,077,440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,060,900.00	9,881,540.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	145,188,713.39	110,441,408.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,236,713.00	77,636,481.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,033,389.00	77,636,481.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,996,889.00	77,636,481.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,036,500.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,203,324.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,203,324.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,944,720,063.64	2,166,137,809.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-50,603,092.34	252,704,203.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	937,985,569.99	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	937,985,569.99	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-937,985,569.99	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-988,588,662.33	252,704,203.60

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,855,731,800.00	2,014,995,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	465,000.00	300,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	465,000.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	465,000.00	300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	465,000.00	300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,855,266,800.00	2,014,695,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,756,019,400.00	1,923,404,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,756,019,400.00	1,923,404,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,247,400.00	91,291,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,247,400.00	91,291,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,806,011,495.76	2,024,697,004.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,806,011,495.76	2,024,697,004.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,721,614,791.76	1,948,473,704.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,352,047,649.34	1,577,027,662.71
210101	Үндсэн цалин	775,671,275.18	896,986,874.23
210102	Нэмэгдэл	474,946,604.16	558,435,078.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт		36,040,400.00
210104	Урамшуулал	101,429,770.00	85,565,309.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,457,732.00	191,621,000.00
210201	Тэтгэврийн даатгал	105,817,932.00	130,302,600.00

**Архангай аймгийн Хангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	13,660,000.00	15,329,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,830,000.00	7,664,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,830,000.00	7,664,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,319,800.00	30,659,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,044,076.00	86,291,100.00
210301	Гэрэл, цахилгаан	16,346,996.00	23,692,701.00
210302	Түлш, халаалт	59,019,600.00	56,735,899.00
210303	Цэвэр, бохир ус	4,677,480.00	5,862,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	37,011,020.00	44,714,300.00
210502	Хоол, хүнс	37,011,020.00	44,714,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	13,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,895,122.35	11,860,741.77
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,895,122.35	11,860,741.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,159,192.07	35,958,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,023,892.07	28,203,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,135,300.00	7,755,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,396,704.00	76,223,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,193,380.00	76,223,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,156,880.00	76,223,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,036,500.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,203,324.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,203,324.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,720,304.24	-9,701,304.48
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,013,670.00	30,925,250.00
	Дотоод эх үүсвэрээр	27,013,670.00	30,925,250.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,013,670.00	30,925,250.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-27,013,670.00	-30,925,250.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,706,634.24	-40,626,554.48
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		63,251,112.20
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,624,557.72

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт дүн
1	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	393,058,319.88	184,006,966.23	3,039,750,539.69		3,616,815,825.80
2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
3	Тайлант үеийн үр дүн			252,704,203.60		252,704,203.60
5	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,058,319.88	184,006,966.23	3,292,454,743.29		3,869,520,029.40

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,027,556,000.00	2,014,695,700.00	12,860,300.00	99.37
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,936,264,900.00	1,923,404,600.00	12,860,300.00	99.34
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,936,264,900.00	1,923,404,600.00	12,860,300.00	99.34
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,291,100.00	91,291,100.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	91,291,100.00	91,291,100.00		100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	63,527,300.00	300,000.00	63,227,300.00	0.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	300,000.00		100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	63,227,300.00		63,227,300.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>2,091,083,300.00</b>	<b>2,014,995,700.00</b>	76,087,600.00	96.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>2,091,083,300.00</b>	2,055,622,254.48	35,461,045.52	98.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,013,240,700.00	1,979,398,954.48	33,841,745.52	98.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,601,507,100.00	1,577,027,662.71	24,479,437.29	98.47
210101	Үндсэн цалин	972,524,700.00	896,986,874.23	75,537,825.77	92.23
210102	Нэмэгдэл	585,456,900.00	558,435,078.94	27,021,821.06	95.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт		36,040,400.00	-36,040,400.00	
210104	Урамшуулал	43,525,500.00	85,565,309.54	-42,039,809.54	196.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,188,500.00	191,621,000.00	8,567,500.00	95.72
210201	Тэтгэврийн даатгал	136,128,100.00	130,302,600.00	5,825,500.00	95.72
210202	Тэтгэмжийн даатгал	16,015,000.00	15,329,600.00	685,400.00	95.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,007,600.00	7,664,700.00	342,900.00	95.72
210204	Ажилгүйдлийн даатгал	8,007,600.00	7,664,700.00	342,900.00	95.72
210205	Эрүүл мэндийн даатгал	32,030,200.00	30,659,400.00	1,370,800.00	95.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,291,100.00	86,291,100.00		100
210301	Гэрэл, цахилгаан	22,931,100.00	23,692,701.00	-761,601.00	103.32
210302	Түлш, халаалт	53,760,000.00	56,735,899.00	-2,975,899.00	105.54
210303	Цэвэр, бохир ус	9,600,000.00	5,862,500.00	3,737,500.00	61.07

2105	Норматив зардал	44,864,400.00	44,714,300.00	150,100.00	99.67
210502	Хоол, хүнс	44,864,400.00	44,714,300.00	150,100.00	99.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,755,000.00	22,265,991.77	489,008.23	97.85
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,755,000.00	22,265,991.77	489,008.23	97.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,634,600.00	52,478,900.00	155,700.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,864,400.00	44,723,700.00	140,700.00	99.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,770,200.00	7,755,200.00	15,000.00	99.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,333,600.00	76,223,300.00	2,110,300.00	97.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,333,600.00	76,223,300.00	2,110,300.00	97.31
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	78,333,600.00	76,223,300.00	2,110,300.00	97.31
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	<b>2,091,083,300.00</b>	<b>2,055,622,254.48</b>	35,461,045.52	98.28
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		63,251,112.20	-63,251,112.20	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,624,557.72	-22,624,557.72	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй, залруулаагүй 12,300.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 12,300.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 23,524.6 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

##### 3.1.1. Худалдан авалттай холбоотой:

**Илрүүлэлт:** Тайлант онд 12,300.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цахим худалдан авалттай холбоотой	1	12,300.0			1	12,300.0							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>12,300.0</b>			<b>1</b>	<b>12,300.0</b>							